

## Нээлттэй мэдээллийн ил тод байдлыг хангахад

аймгийн албан ёсны цахим хуудсанд цахимаар байршуулах мэдээллүүд:

2023-04-14

8.6.5. төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ноогдол ашиг;

Сэлэнгэ баялаг ирээдүй Орон нутгийн өмчийн орлоотой ХХК нь гадаад дотоод худалдаа, Уул уурхай ашиг малтмалын чиглэлээр зөвөлгөө өгөх чиглэлээр байгуулагдсан. Орон нутгийн оруулсан хөрөнгийн дүн эзлэх хувь нь 34 сая төгрөг буюу 34 хувь. Алдагдал нь 13.7 мянган төгрөг, татварын хэмжээ нь 81.1 мянган төгрөг, ноогдол ашиггүй байна.

Сэлэнгэ хаш баялаг Орон нутгийн өмчийн орлоотой ХХК нь гадаад дотоод худалдаа, Уул уурхай ашиг малтмалын чиглэлээр зөвөлгөө өгөх чиглэлээр байгуулагдсан. Орон нутгийн оруулсан хөрөнгийн дүн эзлэх хувь нь 20 сая төгрөг буюу 20 хувь. Алдагдалгүй, татварын үүсээгүй, ноогдол ашиггүй байна.

Сэлэнгэ ресурс Орон нутгийн өмчийн орлоотой ХХК нь гадаад дотоод худалдаа, Уул уурхай ашиг малтмалын чиглэлээр зөвөлгөө өгөх чиглэлээр байгуулагдсан. Орон нутгийн оруулсан хөрөнгийн дүн эзлэх хувь нь 20 сая төгрөг буюу 20 хувь. Алдагдалгүй, татварын үүсээгүй, ноогдол ашиггүй байна.

Аймгийн ИТХТ-ийн 2017 оны 73, 107, 108 дугаар тогтоолуудаар ашигт малтмалын хайгуул, ашиглалтын болон байгаль орчныг нөхөн сэргээх чиглэлээр үйл ажиллагаа эрхлэн явуулах чиглэл бүхий орон нутгийн өмчийн оролцоотой дараах компаниудыг үүсгэн байгуулсан. 2017 онд үүсгэн байгуулагдсан дээрх компаниудын хувь эзэмших зорилгоор байгуулсан /төрийг төлөөлж/ “Сэлэнгэ баялаг ирээдүй” ОНӨААТҮГ нь компаниудын гаргасан энгийн хувьцааны 20-34 хувийг үнэ төлбөргүй эзэмшихээр дүрэмд тусгасан. Аймгийн ИТХТ-ийн 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 42 дугаар тогтоолоор “Сэлэнгэ байгалийн нөөц” ХХК-ийн 34 хувийн хувьцаа эзэмшигч “Сэлэнгэ баялаг ирээдүй” ОНӨААТҮГ-ын хувьцаанаас 8 хувийг Баянгол суманд эзэмшүүлэх шийдвэр гаргасны дагуу тус сумын ИТХТ-ийн 2019 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 08 дугаар тогтоолоор Баянголын хөгжлийн гүүр ОНӨААТҮГ -ыг үүсгэн байгуулсан.

8.6.6. төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл;

Б.Ариунбат захиралтай Сэлэнгэ баялаг ирээдүй Орон нутгийн өмчийн орлоотой ХХК нь орон нутгийн оруулсан хөрөнгийн дүн эзлэх хувь нь 34 сая төгрөг буюу 34 хувь. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд орох орон нутгийн өмчийн төлөөлөгчөөр Аймгийн Засаг даргын орлогч Ж.Сайнцог, Орон нутгийн өмчийн газрын дарга П.Эрдэнэсайхан, Баруунбүрэн сумын иргэн Т.Данзандорж нар байна. Үйл ажиллагаа явуулаагүй тул цалин хөлс 2021, 2022 онд гараагүй.

Ч.Хаш-Эрдэнэ захиралтай "Сэлэнгэ хаш баялаг" орон нутгийн өмчийн орлоотой ХХК нь орон нутгийн оруулсан хөрөнгийн дүн эзлэх хувь нь 20сая төгрөг буюу 20 хувь. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд орох орон нутгийн өмчийн төлөөлөгчөөр Аймгийн Засаг даргын орлогч Ж.Сайнцог, Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Э.Оюунболд нар байна. Үйл ажиллагаа явуулаагүй тул цалин хөлс 2021, 2022 онд гараагүй.

Д.Бямбабазар захиралтай "Сэлэнгэ ресурс" орон нутгийн өмчийн орлоотой ХХК нь орон нутгийн оруулсан хөрөнгийн дүн эзлэх хувь нь 20сая төгрөг буюу 20 хувь. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд орох орон нутгийн өмчийн төлөөлөгчөөр Аймгийн Засаг даргын орлогч Ж.Сайнцог, Орон нутгийн өмчийн газрын дарга П.Эрдэнэсайхан. нар байна. Үйл ажиллагаа явуулаагүй тул цалин хөлс 2021, 2022 онд гараагүй.

8.6.8. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл;

2022 онд дуудлагын худалдааг зохион байгуулан явуулж 34,865,000 төгрөгийн орлогыг төрийн санд төвлөрүүлсэн байна.

Аймгийн ИТХ-аар батлагдсан тогтоолын дагуу 200,220,192.82 төгрөгийн хөрөнгө акталж, балансаас балансад 1,115,780,360 төгрөгийн хөрөнгө шилжүүлэн ажиллалаа.

Орон нутгийн өмчийг түрээсэлдэг байгууллагуудтай түрээсийн гэрээ хийж 18,603,000 төгрөгийн орлогыг төрийн санд төвлөрүүлсэн байна.

3. Дуудлагын автомашины зориулалтаар хуваарилан шилжүүлснээс бусад автомашиныг төрийн холбогдох байгууллагын зайлшгүй шаардлага, хэрэгцээг харгалзан эрэмбэлсний үндсэн дээр зарим хэсгийг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.5-д заасан байгууллагад албан ажлын зориулалтаар хуваарилах, үлдэх хэсгийг дуудлага худалдаагаар худалдан борлуулж, орлогыг улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тоот тогтоол, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын хамтарсан 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 95/260 тоот тушаалаар батлагдсан "Төрийн байгууллага,

төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам” батлагдаж журмын дагуу аймгийн Засаг даргын захирамжийн төслийг боловсруулан ажиллаж байна.

9. Автомашины хэрэглээг хязгаарласан, автомашин төвлөрүүлэн, шилжүүлсэнтэй холбогдуулан жолооч нарыг үргэлжлүүлэн ажиллуулах, шаардлагатай бол шилжүүлэн байршуулах, ингэхдээ тэдний орлого, нийгмийн баталгааг одоо байгаа түвшнээс бууруулахгүй байх арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэхийг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, төсвөөс санхүүжилт авдаг бүх байгууллагын дарга нарт тус тус даалгасугай.

Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тоот тогтоол, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын хамтарсан 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 95/260 тоот тушаалаар батлагдсан “Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам” батлагдаж журмын дагуу аймгийн Засаг даргын захирамжийн төслийг боловсруулан ажиллаж байна.

АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР